



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БУСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК
-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/85/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Хосжаргал

Утас: 261628 Цахим хаяг: khojargalts@audit.gov.mn

Аудитор: Ж.Нямцэцэг

Утас: 260512 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Монголиан бизнес рейтинг
аудит ХХК

Захирал: Д.Түмэнжаргал

Цахим хаяг: Mbr.audit.llc@gmail.com

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
6. Завсрлын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Албан шаардлага	15
8.2 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж Ахуй Нэгжийн Орлогын Албан Татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БЗӨБЦТС	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
ЗГ	Засгийн Газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТҮЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал



ҮНДСПИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.МӨНГӨНХӨЛӨГТ ТАНАА

2022.03.15 № 07/581
танийн № -г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 33 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 107,628.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 108,679.2 сая төгрөгөөр, алдагдлыг 1,260.1 сая төгрөг байхаар тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр 110,985.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 110,933.8 сая төгрөгийн зардал гарган, 621.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Бусад асуудал

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК тайлант онд 13 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийг 84.6 хувьтай гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланда хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Няглан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг ипрюүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланда үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,912,458,534.29	1,393,266,291.94
1.1.2	Дансны авлага	2,588,223,550.61	3,911,342,639.91
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	3,114,737.33	382,357,648.00
1.1.4	Бусад авлага	37,177,433.11	190,853,079.15
1.1.6	Бараа материал	1,425,950,372.15	1,486,375,330.77
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	29,061,000.00	28,498,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,355,678,991.13	7,392,692,989.77
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	151,480,205,847.64	156,251,083,767.31
1.2.2	Биет бус хөрөнгө	1,825,052,227.98	1,784,596,974.28
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	153,305,258,075.62	158,035,680,741.59
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	159,660,937,066.75	165,428,373,731.36
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	794,182,905.32	335,655,861.32
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	402,629,368.82	245,321,155.21
2.1.1.12	Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг	45,631,978.35	83,470,545.54
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,535,003,387.85	664,447,562.07
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	7,676,596,630.88	14,217,276,572.05
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	135,294,579.34	639,898,092.91
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,811,891,210.22	14,857,174,664.96
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,346,894,598.07	15,521,622,227.03
2.3.1	Өмч: - төрийн	33,766,009,000.00	62,531,339,800.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	79,541,703,795.42	79,374,890,274.17
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	30,479,235,882.25	4,065,812,537.66
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,527,093,791.01	3,934,708,892.50
2.3.11	Эздийн өмчийн дүн	148,314,042,468.68	149,906,751,504.33
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	159,660,937,066.75	165,428,373,731.36

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	96,205,310,801.00	109,159,125,313.85
2	Борлуулалтын өртөг	91,954,410,763.49	104,864,737,318.41
3	Нийт ашиг (алдагдал)	4,250,900,037.51	4,294,387,995.44
5	Хүүний орлого	20,434,649.75	
8	Бусад орлого	1,423,294,091.99	1,804,283,632.03
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,262,557,099.28	3,337,595,781.34
10	Ерөнхий ба удирдлагын зардал	684,997,279.51	758,239,800.57
12	Бусад зардал	414,060,923.05	1,485,578,401.06
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(173,754,972.89)	2,695,024.05

14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(253,020,954.66)	(468,577,988.19)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	906,237,549.86	51,374,680.36
19	Орлогын татварын зардал	447,116,818.39	673,106,621.60
20	Татварын дараах ашиг (алдагдал)	459,120,731.47	(621,731,941.24)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	459,120,731.47	(621,731,941.24)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
25	Орлогын нийт дүн		
26	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМЧ	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	33,766,009,000.00	79,694,305,494.68	2,936,048,111.29	4,014,041,360.28	120,410,403,966.25
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				459,120,731.47	459,120,731.47
Бусад дэлгэрэнгүй орлого			27,543,187,770.96		27,543,187,770.96
Өмчид гарсан өөрчлөлт					-
Зарласан ногдол ашиг				(98,670,000.00)	(98,670,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(152,601,699.26)		152,601,699.26	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	33,766,009,000.00	79,541,703,795.42	30,479,235,882.25	4,527,093,791.01	148,314,042,468.68
Няялан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(68,598,368.52)	(68,598,368.52)
Залруулсан үлдэгдэл	33,766,009,000.00	79,541,703,795.42	30,479,235,882.25	4,458,495,422.49	148,245,444,100.16
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(621,731,941.24)	(621,731,941.24)
Бусад дэлгэрэнгүй орлого			2,351,907,455.41		2,351,907,455.41
Өмчид гарсан өөрчлөлт	28,765,330,800.00		(28,765,330,800.00)		-
Зарласан ногдол ашиг				(68,868,110.00)	(68,868,110.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(166,813,521.25)		166,813,521.25	-
2021 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	62,531,339,800.00	79,374,890,274.17	4,065,812,537.66	3,934,708,892.50	149,906,751,504.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	72,940,034,836.47	85,360,030,835.30
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	70,351,913,432.37	83,392,059,119.56
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	93,223,553.50	93,626,104.00
	Бусад мөнгөн орлого	2,494,897,850.60	1,874,345,611.74
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	68,147,603,885.46	82,123,389,394.09
	Ажиллагчдад төлсөн	10,343,139,691.78	10,447,160,391.90
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,005,266,919.67	3,105,106,451.29
	Бараа материал худалдан авахад төлсөн	47,564,778,505.54	57,822,019,431.95
	Ашиглалтын зардалд төлсөн	479,651,667.16	455,919,173.14
	Түлш шатахуун, тээврийн хэлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	660,669,088.02	733,521,492.80
	Хүүгийн төлбөрт төлсөн	311,231,102.12	391,264,891.85
	Татварын байгууллагад төлсөн	4,065,571,012.25	3,593,916,197.03
	Даатгалын төлбөрт төлсөн	30,002,333.00	135,805,970.86
	Бусад мөнгөн зарлага	1,687,293,565.92	5,438,675,393.27
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,792,430,951.01	3,236,641,441.21
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	24,050,156.11	1,100,000.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	3,700,000.00	1,100,000.00
	Хүлээн авсан хүүгийн орлого	20,350,156.11	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,999,121,323.10	3,686,991,867.50
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,999,121,323.10	3,686,991,867.50
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,975,071,166.99)	(3,685,891,867.50)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,531,609,395.00	1,282,066,230.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	4,531,609,395.00	1,282,066,230.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,631,353,101.06	1,352,008,046.06
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	4,532,683,101.06	1,283,139,936.06
	Төлсөн ногдол ашиг	98,670,000.00	68,868,110.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(99,743,706.06)	(69,941,816.06)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	717,616,077.96	(519,192,242.35)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний улдэгдэл	1,194,842,456.33	1,912,458,534.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн улдэгдэл	1,912,458,534.29	1,393,266,291.94

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 он	2021 он		Зөрүү	
				Зорилт	Гүйцэтгэл	дүн	хувь
1	Худалдан авсан ЦЭХ	сая кВт*ч	440.6	495.6	506.1	10.5	102.1%
	үүнээс: ДҮТ ХХК-иас	сая кВт*ч	440.0	495.0	505.3	10.3	102.1%
	Импортоор	сая кВт*ч	0.62	0.62	0.76	0.1	122.6%
2	Түгээлтийн алдагдал хувиар	хувь	5.12%	6.1%	6.29%	0.2%	103.1%
	биетээр	сая кВт*ч	22.5	30.2	31.8	1.6	105.3%
	үүнээс: Импортын алдагдал хувиар	хувь	16.87%	16.87%	11.05%	(5.82) %	65.5%
	Импортын алдагдал биетээр	сая кВт*ч	0.12	0.105	0.08	(0.03)	76.2%
3	Борлуулсан ЦЭХ	сая кВт*ч	417.8	465.4	474.2	8.8	101.9%
	үүнээс: ДҮТ ХХК-иас	сая кВт*ч	417.3	464.8	473.5	8.7	101.9%
	Импортоор	сая кВт*ч	0.50	0.515	0.678	0.2	131.7%
	Борлуулалтын дундаж үнэ	Төгр/кВт*ч	181.91	182.04	182.08	0.04	100.0%
4	Нийт орлого	сая төг	97,693.5	107,628.4	110,985.2	3,356.8	103.1%
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	75,953.3	84,618.7	86,222.6	✓ 1,603.9	101.9%
	Түгээх үйлчилгээний орлого	сая төг	20,140.9	21,713.0	22,127.3	✓ 414.3	101.9%
	Импортын эрчим хүчиний орлого	сая төг	111.1	104.6	160.0	55.4	153.0%
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	1,488.2	1,192.2	2,475.4	1,283.2	207.6%
5	Нийт зардал	сая төг	96,787.3	108,679.2	110,933.8	2,254.6	102.1%
	Үүнээс: ХАЦЭХ-ний зардал	сая төг	71,627.8	82,153.9	83,921.9	✓ 1,768.0	102.2%
	ХАЦЭХ-ний тариф	Төгр/кВт*ч	162.8	166.0	166.08	0.1	100.0%
	Хангах, түгээх ажиллагааны зардал	сая төг	24,127.3	25,413.4	24,855.4	✓ (558.0)	97.8%
	Импортын эрчим хүчиний зардал	сая төг	146.9	167.5	183.2	15.7	109.4%
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	885.3	944.4	1,973.3	1,028.9	208.9%
6	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	сая төг	906.2	(1,050.7)	51.4	1,102.1	(4.9) %
	Орлогын албан татвар	сая төг	447.1	209.3	673.1	463.8	321.6%
	Цэвэр ашиг, алдагдал	сая төг	459.1	(1,260.1)	(621.7)	1,719.2	(36.4) %
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.99	1.01	1.00	(0.01)	99.0%
9	Нийт авлага	сая төг	2,628.5	2,882.0	4,484.6	1,602.6	155.6%
	үүнээс: Хэрэглэгчдээс авах авлага	сая төг	928.9	1,500.0	998.7	(501.3)	66.6%
	Засгийн газраас авах авлага	сая төг	1,634.7	900.0	2,220.3	1,320.3	246.7%
	Шөнийн тарифын хөнгөлөлтийн авлага	сая төг	24.6	441.1	245.4	(195.7)	55.6%
	ДҮТ-ээс авах авлага	сая төг	-	-	445.4	445.4	100.0%
	Бусад авлага	сая төг	40.3	40.9	574.8	533.9	1405.4%
10	Нийт өр төлбөр	сая төг	10,766.3	22,944.9	15,521.6	(7,423.3)	67.6%
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	7,811.9	20,441.7	14,857.2	(5,584.5)	72.7%
	Богино хугацаат өр төлбөр	сая төг	2,954.4	2,503.2	664.4	(1,838.8)	26.5%
	Үүнээс: НХА-ийн өглөг	сая төг	2,292.1	2,128.1	-	(2,128.1)	(100.0) %
	ЦЭХ-ний УТТ	сая төг	213.6	375.1	335.7	(39.4)	89.5%
	Бусад өглөг	сая төг	-	-	328.8	328.8	100.0%
11	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая төг	4,887.0	6,256.1	3,574.3	(2,681.8)	57.1%
үүнээс	Хөрөнгө оруулалт	сая төг	449.0	1,563.7	636.3	(927.4)	40.7%
	Их засвар	сая төг	332.0	490.0	446.6	(43.4)	91.1%
	ТЗБАХ	сая төг	4,106.0	4,202.4	2,491.4	(1,711.0)	59.3%
12	Нийт ажиллагсдын тоо	хүн	547	552	552	-	100.0%
	Нийт цалингийн сан	сая төг	10,932.0	11,444.0	11,256.9	(187.1)	98.4%
13	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,665.7	1,727.7	1,699.4	(28.3)	98.4%

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланда аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланда компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланда шалгагдагч байгууллагад НӨАТ-ын тайлангийн зөрүү, төсвийн зарцуулалт, худалдан авалт, өртөг зардал болон бусад хууль тогтоомжтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 25-аас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Монголиан бизнес рейтинг аудит ХХК-ийн аудитор А.Жамъян, туслах аудитор Г.Буянбадрах нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Н.Алтанзул, ерөнхий захирал Д.Түмэнжаргал нар хэрэгжүүлсэн.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/166 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа боловч шинэчилсэн санхүүгийн программ хангамжид өөрчлөлтийг хийгээгүй байна.

Дотоод хяналтын хэлтэс нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд оновчтой арга хандлагаар санхүүгийн хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлж хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах, үр өгөөж, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой дүгнэлт гарган байнгын сайжруулалт хийх замаар эрсдэлийг бууруулах, засаглал ба дотоод хяналтыг үр нөлөөтэй болгоход чиглэн хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Цар тахал өвчний улмаас төлөвлөгөөт хяналт шалгалтуудыг товлосон хугацаанд хийж чадаагүй, өмнөх оны худалдан авах ажиллагаа болон удирдах дээд байгууллагаас өгөгдсөн 5 үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуултын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоо.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 97,649.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 976.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоо шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх станц ТӨХК-ийн зорилго нь тодорхой үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэртэй хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай бүрэн хангах замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж тэдгээрийн ашиг сонирхлыг ханган ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгаан эрчим хүч түгээх, зохицуулалттай хангах ажил, үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлжээ.

Улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компанийн статустай гэж тодорхойлж, Эрчим хүчний яам 70.0 хувь, ТӨБЗГ 30.0 хувь буюу өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх станц ТӨХК нь Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна.

Эн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй, 9 дүгээр зүйлийн 5-д хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах гэсэн заалттай нийцэж байна.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх станц ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор ТҮЗ-д төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй 7 гишүүнийг, 02 дугаар тогтоолоор ТҮЗ-ийн хараат бус 3 гишүүнийг томилсон байна.

ТҮЗ-ийн 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Компанийн гүйцэтгэх захирлыг томилох тухай 21 дүгээр тогтоолоор гүйцэтгэх захирлыг томилсон байна.

Компанийн ТҮЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар, гүйцэтгэх удирдлагыг ТҮЗ-ийн тогтоолоор томилсон нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д “Төлөөлөл удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох”, 76.1.8-д “компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох” гэсэн заалтуудтай нийцэж байна.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх станц ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 03 дугаар тогтоолоор ТҮЗ-ийн даргын урамшууллыг 0.8 сая төгрөг, гишүүдийн урамшууллыг 0.7 сая төгрөг, нарийн бичгийн даргын урамшууллыг 0.6 сая төгрөг сар бүр олгохоор тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан

“Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 100.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 97.9 сая төгрөг зарцуулсан байна.

Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд ТӨБЗГ-ын 2017 оны А/135 дугаар тушаалын дагуу 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 2017/УБ/14-0511 дугаартай “Өмч эзэмшлийн гэрээ”-г сунган, компанийн 2020 оны байдлаарх нийт хөрөнгө болох 5,758 ширхэг 173,943.6 сая төгрөгийн хөрөнгийн мэдээллийг холбогдох маягтуудаар баталгаажуулан, гэрээний хэрэгжилтийг 98.0 хувь гэж дүгнэсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т заасны дагуу Гүйцэтгэх захирлын 2021 оны А/331 дүгээр тушаалаар дотоод зохион байгуулалтын чиг үүргийн давхардлыг арилгаж, бүх ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2020 оны 211 дүгээр тогтоол Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай”.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх станц ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,912,458.5	1,393,266.3	(519,192.2)
Авлага	2,628,515.7	4,484,553.4	1,856,037.7
Урьдчилгаа	359,693.4	0.0	(359,693.4)
Бараа материал	1,455,011.4	1,514,873.3	59,861.9
Үндсэн хөрөнгө	151,480,205.8	156,251,083.7	4,770,877.9
Биет бус хөрөнгө	1,825,052.2	1,784,596.9	40,455.3
Нийт хөрөнгийн дүн	159,660,937.1	165,428,373.7	5,767,436.6
Өр төлбөрийн дүн	11,346,894.6	15,521,622.2	4,174,727.6
Богино хугацаат өглөг	3,535,003.4	664,447.6	(2,870,555.8)
Урт хугацаат өглөг	7,811,891.2	14,857,174.7	7,045,283.5
Эздийн өмч	148,314,042.5	149,906,751.5	1,592,709.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	159,660,937.1	165,428,373.7	5,767,436.6

Касс дахь бэлэн мөнгө 4.9 сая төгрөг, арилжааны 3 банкны 12 харилцах дансанд 1,388.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт авлага 1,856.0 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр “Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын хүрээнд айл өрх, аж ахуйн нэгжийн цахилгааны төлбөрийг төр хариуцах 2,220.3 сая төгрөгийн авлага, нэг худалдан авагчаас авах цахилгаан эрчим хүчиний авлага 445.4 сая төгрөг, шөнийн тарифын хөнгөлөлтийн 245.4 сая төгрөгийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 4,160.2 сая төгрөгийн, 3 сар хүртэлх хугацаа хэтэрсэн 329.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. НББББ-т тусгасны дагуу тайлант онд 5.0 сая төгрөгийн найдвартай авлагын нөөц байгуулсан байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 359.7 сая төгрөгийн гэрээт ажлыг гүйцэтгэгч байгууллага гүйцэтгэснийг дүгнэн, тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,514.9 сая төгрөг болж, 59.9 сая төгрөгөөр өссөн нь хил хаагдсанаас урсгал засварын ажлын материал тайлант оны сүүлчээр хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 1,862.7 сая, ТӨБЗГ-ын 2021 оны 578 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагад шилжүүлсэн 2,223.6 сая, ТӨБЗГ-ын 64 дүгээр тогтоолоор Капитал банкаас авах авлагад тооцон авсан суудлын автомашин 38.0 сая, Эрчим хүч-2 төслийн хөрөнгө оруулалтын ажлын тайлант онд нэмэгдсэн дуусаагүй барилга 6,987.0 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 183, 588 дугаар тогтоолоор акталсан 991.6 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгчид өгөх 245.3 сая, урт хугацаат өр төлбөрөөс тайлант хугацаанд төлөгдөх хэсгийг шилжүүлэн бүртгэсэн 37.8 сая, урьдчилж орсон орлого 335.6 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд хойшлогдсон татварын өр 639.9 сая, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Эрчим хүч-2 төслийн зээлийн өглөг 14,217.3 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрөөс тайлант онд Эрчим хүчиний алдагдлыг бууруулах 1492-МОН төслийн дамжуулан зээлийн 1.0 сая төгрөгийг хуваарийн дагуу төлжээ.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Эрчим хүч-2 төслийн зээлийн гэрээний дагуу 2024 оноос төлөгдөж эхлэх, тооцоо нийлж баталгаажуулсан 14,217.3 сая төгрөгийн зээл бүртгэлтэй байна.

Санхүүгийн тайландаа зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад нийт зардал 11,891.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь худалдан авсан цахилгаан эрчим хүчиний зардлын өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 6 дугаар тогтоолоор эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт бүртгэлтэй 28,765.3 сая өмчийг, төрийн өмчид шилжүүлэн бүртгэсэн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 2,223.6 сая, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 79,374.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТҮЗ-ийн 2021 оны 1 дүгээр тогтоолоор Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх станц ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний нийт орлогыг 88,770.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 91,264.7 сая төгрөгөөр, үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 6,256.1 сая төгрөг, алдагдлыг 2,494.3 сая төгрөг байхаар баталсан байна.

ТҮЗ-ийн 2021 оны 33 дугаар тогтоолоор компанийн нийт орлогыг 107,628.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 108,679.2 сая төгрөгөөр, алдагдлыг 1,260.1 сая төгрөгийн байхаар тодотгожээ.

Гүйцэтгэлээр 110,985.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 110,933.8 сая төгрөгийн зардал гарган, 621.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 3,356.8 сая төгрөг буюу 3.1 хувиар давсан нь борлуулалтын тоо хэмжээ болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын өсөлтөөс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 2,254.6 сая төгрөг буюу 2.1 хувиар илүү гүйцэтгэлтэй байгаа нь борлуулалтын тоо хэмжээ өссөнөөр цахилгаан эрчим хүчиний зардал нэмэгдсэн, үндсэн бус үйл ажиллагааны зардал нөлөөлсөн байна.

Их засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөний дагуу 6,256.1 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 6 нэр төрлийн 67 ажилд 3,945.2 сая төгрөгийн зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлж, дуусаагүй гэрээний хугацаа сунгасан 16 ажлын 2,297.1 сая төгрөгийн он дамжсан хөрөнгө оруулалтын ажлууд байна.

Тайлант онд цэвэр алдагдал 621.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 638.4 сая төгрөгөөр бууруулахад орлогын давалт нөлөөлжээ.

ТӨБЗГ-ын 2021 оны 288 дугаар тогтоолын дагуу тайлант онд ашгийн 15 хувь буюу 68.9 сая төгрөгийн ногдол ашиг, түрээсийн орлогын 40.0 хувь буюу 4.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь тайлант онд нийт 60,387.78 сая төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 173 мэдээллийг ил тод хугацаанд нь байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгууллагын захирлын 2021 оны А/358 тушаалаар хөдөлмөрийн аваргын шагналд 4.2 сая төгрөг, ажил мэргэжлийн аваргуудын шагналд 26.5 сая төгрөг, компанийн хүндэт дэвтэрт алдаршуулахад 0.8 сая төгрөг, өргөмжлөл, цом, тууз худалдан авахад 0.9 сая төгрөг, нийт 32.4 сая төгрөгийн шагнал, урамшуулал бусад зардал гаргасан байна. Энэ нь ЗГ-ын Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоол 1.6. “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцэн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллах ЗГ-аас өгсөн тогтоолын хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батlamж мэдэгдлийн тувшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар илрүүлсэн 44.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг запруулсан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,155.2 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 3.5 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс актын биелэлт 100.0 хувь, албан шаардлагын хэрэгжилт 85.0 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	4.6	1	4.6	-	-	100.0
Албан шаардлага	6	2,155.2	6	2,155.2	-	-	85.0
Зөвлөмж	4	3.5	4	3.5	-	-	100.0
Нийт дүн	11	2,163.3	11	2,163.3	-	-	95.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн дараагийн тайлангийн аудитаар он дамжин хийхээр гэрээг сунгасан 2,297.1 сая төгрөгийн 16 ажлын гүйцэтгэл болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн шинэчлэгдсэн санхүүгийн программтай уялдуулан өөрчлөлтийг тусгаж ажилласан эсэхийг авч үзнэ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 333.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 333.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэлтийн бодлогын баримт бичигтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 136.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 976.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Албан шаардлага

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн бүрдэлтэд өөр хуулийн этгээдийн тохирлын гэрчилгээ хавсаргасан, ерөнхий нөхцөл, санхүүгийн болон техникийн чадавхыг хангаагүй тендерт оролцогчийг сонгон шалгаруулсан, ижил шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулан, 197.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-т "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өргтийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно"; 34 дүгээр зүйлийн 34.2-т "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль, холбогдох журмын дагуу зохион байгуулах албан шаардлага өгөв.

Татварын цахим системд НӨАТ-ын авлагын үлдэгдэл 485.3 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь НӨАТ-ын авлага 382.4 сая төгрөг буюу 103.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйл 10.2-т “Бараа, ажил үйлчилгээ борлуулсан тухай бүрд албан татвар ногдуулах хугацааг доор дурдсан үйлдлийн аль түрүүнд хийгдсэн өдрөөр тогтооно, 10.2.1 Борлуулагч бараа, ажил үйлчилгээний борлуулалтын орлогыг хүлээн авсан өдөр, 10.2.2 Бараа ажил үйлчилгээг борлуулж төлбөрийн баримт, нэхэмжлэх үйлдсэн өдөр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НӨАТ-ын тайланг татварын цахим хуудас болон санхүүгийн тайлангийн НӨАТ-ын авлагыг зөрүүгүй дүнгээр тайлагнах, зөрчлийг запруулан бүртгэх. Албан шаардлага өгөх.

Тайлант онд цайны газрыг 100.2 сая төгрөгийн орлого, 136.4 сая төгрөгийн зардал, 36.2 сая төгрөгийн алдагдалтай баталсан. Гүйцэтгэлээр 77.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 110.9 сая төгрөгийн зардалтай 33.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа нь ажилчдын хоолны нэг бүрийн үнийг өртөг зардалтай уялдуулж тогтоогоогүйтэй холбоотой байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т "Захирал дараах эрх, үүрэгтэй", 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цайны газрын ажилчдын хоолны нэг бүрийн үнийг өртөг зардалтай уялдуулан тогтоох, зорилтод түвшний төлөвлөгөөнд орлого, зардлыг алдагдалтай байхаар батлахгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх, Албан шаардлага егөх.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэ санхүүгийн программ хангамжийн өөрчлөлтийг тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, 20.2.2. аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шинэ санхүүгийн программ хангамжтай уялдуулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулж, өөрчлөлтийг тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/А Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн ута	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн ута	Нийт алдаа, зөрчлийн дүн Too	Дүн	Запруулга				Акт	Үнээс Албан шаардлага	Хариуцлага тооцох	Зөвлөмж
						Дун	Тоо	Дун	Тоо				
Санхүүгийн тайлантай асуудлаар													
1	БЭӨБЦС ТӨХК	АХГ- 2022/85/НА- СТА-ТӨА	Татварын цахим системд НӨАТ- ын авлагын улдээдэл 485.3 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь НӨАТ-ын авлагыг 382.4 сая төгрөг, нийт 103.0 сая төгрөгөөр НӨАТ- ын авлага зөрүүгэй байна.	НӨАТ-ын тайланг татварын цахим хуудас болон санхүүгийн тайлантийн НӨАТ-ын авлагыг зөрүүгүү дүнгээр тайланах, зөрчлийг запруулах	1	102,969.7				1	102,969.7		
2	БЭӨБЦС ТӨХК	АХГ- 2022/85/НА- СТА-ТӨА	Тайлант онд цайны газрыг 100.2 сая төгрөгийн орлого, 136.4 сая төгрөгийг зардап, 36.2 сая төгрөгийн алдагдалтай баталсан. Гүйцэтгэлээр 77.9 сая төгрөгийн орлогын бүрдүүлж, 110.9 сая төгрөгийн зардалтай 33.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа нь ажилчдын хоолын нэг бүрийн үнийг өртөг зардалтай үлдүүлж тогтоодоггүйтэй холбоотой байна.	Цайны газрын ажилчдын хоолны наг бүрийн үнийг өртөг зардалтай үлдүүлэн тогтоох, зорилтод тувшиний төлөвлөгөөнд орлого, зардлыг алдагдалтай байхаар батлахгүй	1	33,098.6				1	33,098.6		
3	БЭӨБЦС ТӨХК	АХГ- 2022/85/НА- СТА-ТӨА	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт санхүүгийн программыг хангамжийн еөрчлөлтийг туслаагүй байна.	Шинэ санхүүгийн программ хангамжтай үлдүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичийг сайжруулж,						1			

Багануур зүн нэд бусийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан

				Бүрчлэлтийг тусгах.	
4	БЗӨБЦС ТӨХК	АХГ-2022/85/НА-СТА-ТӨА	Жаргалтхаан сумын дунц болон нам хүчээгийн хангамжийн шинэчлэлт хийх ажил гүйцэтгэч шалгарууллахад "Мост Кинг" ХХК-ийн Сип-50 дамжуулах угсанд тохирлын гарчилгээ шаардан өөр хуулийн этгээдийн тохирлын гарчилгээг шалгаруулалтад ашигласан байна.	1	-
5	БЗӨБЦС ТӨХК	АХГ-2022/85/НА-СТА-ТӨА	Тайланд онд "Таван тайхар" ХХК-тай шууд гэрээ байгуулахдаа өөр этгээдийн тохирлын гарчилгээг ашигласан, Мөн ТБОНӨХБАУХА тухай хуулийн 14-16 дугаар зүйлийг хангагуй шалгаруулсан байна.	Хурдалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах	1
6	БЗӨБЦС ТӨХК	АХГ-2022/85/НА-СТА-ТӨА	Ижил шинж чанартай машин сэлбэг, бичиг хэрэг, ургасал засварын материал, хангамжийн материалын гэх мэт бараа, ажил, үйлчилгээг нийт төсөвт өртийг хувааж, шууд гэрээ байгуулан 197.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.	197,300.0	1 197,300.0
		ДҮН		6	333,368.3
		Санхүүгийн тайлланын асуудлаар шалгасан нийцлийн асуудал			
1	БЗӨБЦС ТӨХК	АХГ-2022/85/НА-СТА-ТӨА	Байгууллагын захирлын 2021 оны А/358 тушаалаар хөдөлмөрийн аваргын шагналд 4.2 сая төгрөг, ажил мэргэжлийн аваргуудын шагналд 26.5 сая төгрөг, компанийн хундэт дэвтэрт алдаршууллахад 0.8 сая төгрөг, өргөмжлэл, цом, туузны зардалд 0.9 сая төгрөг, нийт 32.4 сая төгрөгийн шагнал, урамшуулал бусад зардал гаргасан байна.	1	32,366.0
		ДҮН		1	32,366.0
		НИЙТ ДҮН		7	365,734.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022

оны 03

дугаар сарын 15

№ 554/АО150055

АХГ-2022/85/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Г

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Татварын цахим системд НӨАТ-ын авлагын үлдэгдэл 485,327,359.65 төгрөг, санхүүгийн тайлан дахь НӨАТ-ын авлага 382,357,648.00 төгрөг буюу 102,969,711.65 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Бараа, ажил үйлчилгээ борлуулсан тухай бүрд албан татвар ногдуулах хугацааг доор дурдсан үйлдлийн аль түрүүнд хийгдсэн өдреэр тогтооно", 10.2.1 "Борлууллагч бараа, ажил үйлчилгээний борлуулалтын орлогыг хүлээн авсан өдөр", 10.2.2 "Бараа, ажил, үйлчилгээг борлуулж төлбөрийн баримт, нэхэмжлэх үйлдсэн өдөр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирагааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Татварын цахим систем дэх нэмэгдсэн өргтийн албан татварын үлдэгдлийн зөрүүг татварын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Мөнгөнхөлөгт, Ерөнхий нягтлан бодогч Т.Болдсанаа нарт даалгав.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ХОСЖАРГАЛ

МОНГОЛИЙН БИЗНЕС РЕЙТИНГ
АУДИТ ХХК ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Д.ТУМЭНЖАРГАЛ



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 03 дугаар сарын 15 № 553/A0150055
АХГ-2022/185/НА-СТА-70A

Улаанбаатар хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цайны газрыг 100,182,100.00 төгрөгийн орлого, 136,430,200.00 төгрөгийн зардал, 36,248,100.00 төгрөгийн алдагдалтай баталсан. Гүйцэтгэлээр 77,872,200.00 төгрөгийн орлогыг бүрдүүлж, 110,970,800.00 төгрөгийн зардалтай 33,098,600.00 төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа нь ажилчдын хоолны нэг бүрийн үнийг өртөг, зардалтай уялдуулж тогтоогоогүйтэй холбоотой байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 "Захирал дараах эрх, үүрэгтэй", 20.1.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрээс биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цайны газрын үйл ажиллагааг алдагдалгүй байхаар ажилчдын хоолны өртөг, зардлыг зөв тооцоолон, үнийг тогтоож, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Мөнгөнхөлөгт, Ерөнхий нягтлан бологч Т.Болдсанаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ХОСЖАРГАЛ

МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ
АУДИТ ХХК ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 552/A0150055
АХГ-2022/85/НА-СТА-ТӨЛ

Улаанбаатар хот

Г Зөрчил арилгах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Үнэлгээний хороо тендер тендерийн баримт бичгийн бүрдэлтэд өөр хуулийн этгээдийн тохирлын гэрчилгээ хавсаргасан, ерөнхий нөхцөл, санхүүгийн болон техникийн чадавхыг хангаагүй тендерт оролцогчийг сонгон шалгаруулсан, ижил шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулж 197,300,00.00 төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийн зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 34 дүгээр зүйлийн 34.2 "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирап Н.Мөнгөнхөлөгт, Ерөнхий нягтлан бодогч Т.Болдсанаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ХОСЖАРГАЛ

МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ
АУДИТ ХХК ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-2-4230

9819120366

Z:Alban Shaardлага\2022\0315 Auditin 2 Gazar-236.Docx

0001081450



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 551/А0150055
АХГ-2022/85/НА-СТА-ТОА

Улаанбаатар хот

Г Зөрчил арилгах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын захирлын 2021 оны А/358 дугаар тушаалаар хөдөлмөрийн аваргын шагналд 4,200,000.00 төгрөг, ажил мэргэжлийн аваргуудын шагналд 26,460,000.00 төгрөг, компанийн хүндэт дэвтэрт алдаршуулахад 840,000.00 төгрөг, өргөмжлөл, цом, туузны зардалд 866,000.00 төгрөг нийт 32,366,000.00 төгрөгийн шагнал, урамшуулалт бусад зардал гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр еслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдаач этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоо, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллах, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандaa мөрдөх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Мөнгөнхөлөгт, Ерөнхий нягтлан бодогч Т.Болдсанаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ХОСЖАРГАЛ

МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ
АУДИТ ХХК ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ